



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 429

Арвайхээр

Ажил хүлээлцэх комисс
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 дахь хэсэг, Татварын хэлтсийн даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн Б/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн жолооч Т.Алтанхуягийн ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнээр байгуулсугай.

Комиссын дарга: А.Ганчимэг (Захиргаа, хуулийн тасгийн дарга)

Гишүүд: Б.Бямбасүрэн (Хуулийн асуудал хариуцсан, хураагч)

С.Отгонлхагва (Нягтлан бодогчийн албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Д.Отгонтуяа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Х.Түвшин (Сүлжээний инженер, нярав)

2. Т.Алтанхуягийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийн дагуу хариуцсан ажлын багаж, төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хөрөнгө, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичиг, биет болон цахим мэдээлэл, холбогдох бусад зүйлийн нэг бүрчлэн бүрэн хүлээлцэхийг Захиргаа, хуулийн тасгийн дарга (А.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ЭРДЭНЭСУВД



621001057